



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

“Ард даатгал” ХХК-д эрх бүхий албан
тушаалтан томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Чулуун овогтой Ганхуяг, гишүүнээр Арьяасүрэн овогтой Батболд, Одончимэд овогтой Одбаяр нарыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Ч.Ганхуяг, А.Батболд, О.Одбаяр нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000580